



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/239

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 9.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татвараас иргэн Х.Анхбаяраар гүйцэтгүүлсэн Улаан-Ам багийн Хужирт, Төмөртийн худаг засварлах, мотор, тоног төхөөрөмж нийлүүлсэн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд: У.Баасандорж (Иргэний төлөөлөл)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Нямтогтох)-д даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татвараын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Улаан-Ам багийн худаг засварын тоног төхөөрөмжийг Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

